

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

ХЯТАДЫН ГАДААД БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛД

Д. Маам

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга К. У. Черненко 1984 оны 2-р сарын 13-нд ЗХУКН-ын Төв Хорооны ээлжит бус бүгд хурал дээр хэлсэн үгэндээ энх тайвныг сахин хамгаалах үйл хэргийн амжилт нь социалист орнууд дэлхийн тавцан дээр хамтын үйл ажиллагаагаа ямар хэмжээнд харилцан зохицуулахаас олон талаар шалтгаална гэж мэдэгдсэн билээ. Коммунист нам, зөвлөлт засгийн газрын энэхүү зарчимт байр суурь гүн гүнзгий уламжлалтай хийгээд зөвлөлт төр, социализмын мөн чанараас урган гарсан ленинч гадаад бодлогын нь амьд бүрэлдэхүүн хэсэг болохыг ЗХУ-ын оршин тогтнож ирсэн үеийн бүх түүх нотлон харуулж байгаа юм.

Тухайлбал ЗХУКН-ын ТХ-ны 1982 оны 11-р сарын бүгд хурал ЗХУКН, ЗХУ социалист бүх оронтой харилцаагаа хөгжүүлэн сайжруулахыг чин сэтгэлээс хүсэж байгааг илэрхийлээд харилцан сайн санаа гаргах, бие биеийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, социализм, энхийн үйл хэргийн төлөө нийтээр санаа тавих явдал нь янз бүрийн учир шалтгаанаар зохих итгэлцэл, харилцан ойлгох явдал хараахан байхгүй байгаа газарт асуудлыг зөв шийдэх аргыг хэлж өгөх ёстой¹ гэж үзжээ. Энэ нь дайн энхийн асуудал хүн төрөлхтөний хамгийн тулгамдсан асуудал болсон өнөөгийн орчин үеийн дэлхий дахины байдлыг марксист ёсоор үнэлж цэгнэсний үндсэн дээр хийсэн буурьтай дүгнэлт, тодорхой улс орны нам, засгийн газарт хандаж гаргасан өндөр үнэ цэнэтэй уриалга байлаа. Тус бүгд хурал энэ асуудал бол «манай их хөрш БНХАУ-д хамаарна»² гэж тодруулж заасан билээ.

ЗХУ-ын алсын хараатай, бодитой, ухаалаг, байнгын энэ байр суурьт хятадын удирдагчид хэрхэн хандахаас хоёр орны харилцаанд сайн талын өөрчлөлт хөгжилт давамгайлах уу, хэвийн зогсонги байдал үргэлжлэх үү гэдэг шийдвэрлэгдэх ёстой билээ. Нөгөө талаар дээрх асуултад ямар хариу гарах нь дэлхий дахинаар яригдаж буй тулгамдсан олон асуудалд шууд хамаарах ёстой болохыг тэмдэглэлтэй. Хятадын удирдагчид удаа дараагаар зөвлөлтийн санал уриалгыг анхаарч үзэх шинжийн мэдэгдэл хийж байсан төдийгүй ХКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан 1983 оны 11-р сарын сүүлээр Токиод айлчилсныхаа дараа хэвлэлийн төлөөлөгчдөд мэдэгдэхдээ зөвлөлт-хятадын хооронд явагдаж байгаа хэлэлцээний байдал «тун сайн» гэж мэдэгдэж байлаа. Гэвч үүгээр ямар нэгэн санааг илэрхий-

¹ «Үнэн». 1982. XII 24

² Мөн тэнд.

³ «Правда», 29 ноября 1983 г.

лээд өнгөрөх, бодит байдал дээр юу хийж байгаа гэдэг бол өөр өөр зүйл юм. Саяхан АНУ-д хийсэн хятадын ерөнхий сайдын зочлолттой холбогдуулж ТАСС-ын нийтэлсэн тайлбар өгүүлэлд энэ айлчлалт ЗХУ, БНХАУ-ын хооронд явагдаж буй хэлэлцээ сэргэх үеийн босгон дэр явагдсанаараа ЗХУ-д дарамт шахалт үзүүлэх хандлага бүхийг дурьдаад, зөвлөлтийн удирдагчидтай «Хятадын эрх баригчид хэлэлцээний ширээнд сууж байгаа нь...шинэ тулгар хөгжиж байгаа орнууд болон энхийг эрхэмлэгч улс түмний нүдний өмнө өөрсдийгөө гутаахаас айхдаа ингэж байгаа хэрэг мөн гэдгийг тэмдэглүүштэй» хэмээн цохож өгүүлсэн нь Бээжингийнхний «...тун сайн» гэсэн мэдэгдлийн цаана чухам юу нуугдан үлдэж буйг гэрэлд гаргаж ирсэн бодитой үнэлэлт болж байна.

Хятадын гадаад бодлогын зохих салбарт үнэн хэрэг дээрээ жижиг сажиг засвар өөрчлөлт мэт зүйл ажиглагдаж байгааг хэн ч үгүйсгэх гээгүй. Тухайлбал худалдаа –эдийн засаг, спорт, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах асуудлаар гаргаж буй Зөвлөлтийн санаачлагад Хятад улс нааштай хандаж байгаад ЗХУ, нийт социалист орнууд, түүний дотор монголын олон нийт талархаж байгаа билээ. Гэвч зөвлөлт-хятадын харилцаа хятадын талын буруугаар ЗХУКН-ын ТХ-оос 1983 оны 8-р сарын 27-нд мэдэгдсэнчилэн «том гүрнүүд, тэгэх тусмаа хөрш орнуудын хооронд байх ёстой харилцааны төвшинд хүртэл чухамдаа их зайтай байгаа» юм. Мөн Бээжингийнхэн Маогийн үед өөрсдөө зохиож, дэлхий дахинаа суртал нэвтрүүлгийн бүх шугамаар цууруулсан ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эсрэг «Олон улсын өргөн фронт»-гэгчийг байгуулах тухай ярихаа цааргалах болжээ. Гэвч нэгдүгээрт, энэ зэргээс болж хятадын гадаад бодлогын мөн чанарт зарчмын өөрчлөлт гарч байна уу, үгүй юу гэдэгт хэргийн учир байна. Нөгөө талаар Болгарын Коммунист Намын онолын сэтгүүл «Ново время»-д тэмдэглэсэнчилэн хятадын удирдагчдын хийж байгаа энэ мэт өнгөц өөрчлөлт нь олон улсын империализм, тухайлан АНУ-ын засаг захиргаа зөвлөлтийн эсрэг үзэл дээр ч хятадын зөвхөн «бага түншээ» гэж илэрхий басамжилж байгаатай шууд уялдаа холбоотой байгаа аж.⁴ Өөрөөр хэлбэл хятадын удирдагчид ийм замаар америкийн империализмыг «айлгаж цочоохыг» хичээж байгаа бололтой. Мөн энэ нь Дэн Сяопин нарын империализмын тал барьсан бодлого хөгжиж байгаа орнуудыг «Зөвлөлтийн эсрэг бүх нийтийн фронт» гэгчид Бээжинтэй нэгтгэх нь байтугай Хятадын нэр хүндийг тэдний дунд гүн гүнзгий гутааж байгаа зэрэг үйл явдалд хятадын удирдлага дүгнэлт хийхээс аргагүйд хүрсэн явдлаар нэгэн зэрэг тайлбарлагдана. Барууныхантай эвсэн сүлбэлдэж ЗХУ-ыг «нэгдүгээр дайсан»-хэмээн зарлаж, Маогийн «соёлын хувьсгал» гэгчийн үеийнх шиг улайрсан тэмцэл явуулах нь «хятадын нийгмийн олон түмний дунд төдийгүй Хятад улсын удирдлагын тодорхой хэсгийн дотор ч дургүйцлийн амьсгаа бий болгож»⁵ байгаа ажээ.

ЗХУКН, зөвлөлт засгийн газар энх тайван, социализмын төлөө цөмийн дайны аюулыг зайлуулахын төлөө бодит социализмын явуулж ирсэн эдүгээ явуулж буй тэмцлийн салшгүй амьд бүрэлдэхүүн хэсэг нь Хятадтай харилцаагаа сайжруулах явдал хэмээн нөр их хүчин зүтгэл гаргасаар байгаа нь нийтэд тодорхой. Гэтэл хятадын удирдагчид энэ асуудал дээр ямар байр суурь баримталж байна вэ? Тэд зөвлөлт-хятадын харилцааг хэвийн болгохын хариулт америкийн импе-

⁴ БКН-ын онолын хэвлэл «Ново время» сониноос дамжуулж иш татлаа. («Новости Монголии», 25 ноября 1983 г)

⁵ Мөн тэнд

риализм, японы милитаризмын өмнө буулт хийхийг ЗХУ-аас шаардаж, манай эх орон БНМАУ, Вьетнам, Кампучи, Афганистантай тогтоосон гэрээний харилцаа, нөхөрсөг хэлхээ холбоогоо муутгах, хүйтрүүлэх асуудлыг зөвлөлтийн талд шууд тулган тавьж байна. Нөгөө талаар Хятадаас социалист орнуудын талаар явуулж байгаа ялгавартай хандах бодлогын цаана ноцтой аюул занал нуугдаж байгааг хэлэх хэрэгтэй. Бээжин Ардчилсан Солонгос, Румын, Югославыг нөхөрсөг орон, Зүүн Европын улсуудыг «жирийн социалист орнууд», ЗХУ, БНМАУ, Куба, Социалист Вьетнамыг «тэмцэл ба хязгаарлагдмал хэлэлцээ явуулах» орнууд гэж үзэж энэтхэг-хятадын хойгийн улсуудыг хавчин гадуурхаж, тэдэнтэй халз тулж тэмцэх байр суурь баримталж байгаа юм. Хятадын энэ бодлогыг империализм, дайны хүчээс өөр хэн ч зөвшөөрөн хүлээж, баяр хүргэн тухирахгүй нь тодорхой билээ.

х х х

Дэлхий дахины өмнө тулгарч байгаа цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулж, хүн төрлөхтний оршин тогтнох, гаригийн хүн бүрийн амьдрах эрхийг баталгаатай болгож өгөх олон улсын харилцааны үндсийн үндэс болсон энх тайвны асуудал дээр хятадын удирдагчдын байр суурь юу болохыг товч авч үзье.

ЗХУКН-ын Төв Хороо В. И. Лениний үндэслэсэн энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын гүн гүнзгий үзэл санааг илэрхийлж, 1983 оны 9-р сарын сүүл үеэр нийтэлсэн мэдэгдэлдээ: «Үзэл суртлын зөрчлийг улс хоорондын харилцааны хүрээнд шилжүүлэх нь гадаад хэрэгт тийм арга хэрэглэж байсан хүмүүст хэзээ ч сайн зүйл болж байгаагүй билээ. Тэгэх тусмаа одоогийн цөмийн эринд энэ нь бүр ч утга учиргүй, байж болшгүй зүйл юм. Үзэл суртлын сөргөлдөөнийг цэрэг дайны өрсөлдөөн болгох нь нийт хүн төрөлхтөнд асар их хохирол учруулахсан билээ»⁶ гэж өгүүлсэн юм. Энэ бол чухамдаа цөмийн дайнд бэлтгэгчид тэднийг тухиран өөгшүүлэгчдэд хандаж өгүүлсэн социалист хамтын нөхөрлөлийн орнуудын уялдан зохицолдсон гадаад бодлогын чин үнэн үг байлаа.

Гэвч АНУ-ын засаг захиргаа, НАТО-гийн дайнч бүлгийнхэн цөмийн дайнд шатлан бэлтгэх үйл ажиллагаандаа эрүүл ухаан санааны дүгнэлт хийсэнгүй.

Баруун Европт америкийн дунд зайны тусгалын «Першинг», далавчит пуужинг нэгэнт байрлуулж, империалистууд цөмийн дайнд бэлтгэх явдлаа шуудруулснаар энэ хэрэг явдал бүх нийтийн санааг түгшээж дайн энхийн асуудлын цөм боллоо.

Гэтэл энэ асуудлаар Бээжингийн баримталж байгаа байр суурь хачирхал, болгоомжлол төрүүлэхэд хүргэж байна.

Өнгөрсөн оны 12-р сарын дундуур Хятадын ГЯЯ-ын сайд У Сюецянь БХАТХ-ын байнгын хорооны хуралдаан дээр дэлхий дахины одоогийн хурцадмал байдлын шалтгааныг «Хоёр жанжлагч (ЗХУ, АНУ)-ийн хоорондын тулалдаан»⁷ гэх томъёоллоор тайлбарлах оролдлого хийжээ. Тэгэх тусмаа У Сюецянийн үгэнд анхааралтай хандах хэрэгтэй байна. Тэрээр «санамсаргүй» буюу зориудаар олж харахгүй, «хоёр жанжлалын» тухай ярьсан мэдэгдэлдээ ЗХУ-ыг америкийн империализмтэй адилтган дайны хүч болгож нэгэн зиндаанд тавьж байсан бол Байнгын хорооны хуралдаанаас хойших хятадын албаны хүмүүсийн мэдэгдэл бүр ч ноцтой анхаарал татах боллоо. Тодруулбал, хя-

⁶ «Үнэн», 1983. IX. 30.

⁷ «Новости Монголии» 13 декабря 1983 г.

тадын удирдагчид хурцадмал байдлын бурууг америкийн империализмаас салгаж ЗХУ-д тохохын тулд бодит байдал, олон улсын харилцааны, мөр нь бүлээнээрээ байгаа баримтыг ч мушгин гуйвуулах оролдлогод шилжсэнийг баримт нотолж байна. БНХАУ-ын ГЯЯ-ын төлөөлөгч Бээжинд болсон хэвлэлийн бага хурал дээр Женевийн хэлэлцээ тасарсан нь Европт америкийн дунд зайны шинэ пуужин байрлуулж эхэлснээс шалтгаалсан бус, «ЗХУ хэлэлцээг зогсоох тухай зарласнаар»⁸ тайлбарлагдана гэж «нотлоод» энэ хэрэг явдлын дараа ЗХУ, АНУ хоёр Европт шинэ пуужингууд зоож эхэллээ гэсэн гүтгэлгийн мэдэгдэл хийсэн юм.

Хятадын төв хэвлэл «Жэньминь жибао» сонин өнгөрсөн оны 12-р сарын сүүлээр «Баруун Европын орнууд өөрийн газар нутаг дээр америкийн дунд зайны тусгалын шинэ пуужин байрлуулахаас аргагүй болсон»⁹ гэж өдөөн турхирсан мэдэгдэл хийжээ. Энэ нь ЗХУ-ын эсрэг «хүчирхэг НАТО зайлшгүй хэрэгтэй» гэх мэтээр Маогийн үед ярьдаг байсан Бээжингийн байр суурийг санагдуулж байна. Чингээд зогсохгүй «Жэньминь жибао» «Зөвлөлт Холбоот Улсын учрууж байгаа цөмийн сүрдүүлэг» гэгч барууныхны суртал нэвтрүүлгийг өгүүлэн бүхий дугаарт улиглан давтсан бол «Синьхуа хороо» бүр ч цааш ахиж америкийн «першинг» болон далавчит пуужинг Европод байрлуулах зайлшгүй шаардлага «ЗХУ дунд зайны тусгалын зэвсгээр тоо чанарын хувьд НАТО, АНУ-аас үзэгдэхүйц давуу байгаа явдлаас урган гарсан юм»¹⁰ гэсэн зүйлийг бичиж байлаа. Энэ бол сонин хэвлэлийн үг төдий биш, Хятад Ард Улсын албан ёсны байр суурь гэдгийг тухайлан тэмдэглэвэл зохино. Европын хамтын нийгэмлэгийн комиссын дарга Г. Тори Дэн Сяопинтэй уулзсанахаа дараа 1983 оны 11-р сарын 6-д мэдэгдэхдээ Хятадын удирдлага «Хятад улс Баруун Европт америкийн пуужингуудыг байрлуулахын төлөө байна» гэж цохож тэмдэглэлээ гэжээ.

Дээр өгүүлснээс үзэхэд «Хятадын удирдагчид империалист гүрнүүд, нэн тэргүүн АНУ-ын балмад бодлогын эрс хүчтэй шуудралтад үг учир нь орших дайны улам бүр нэмэгдэж байгаа бодит шалтгааныг үл ажигч болон, өнөөгийн дэлхий дахины байдлыг жанлал, зөвлөлтийн эсрэг үзлийн хуурамч шилний цаанаас харсан хэвээр байна»¹¹ гэсэн манай улсын төв хэвлэлийн нэг «Новости Монголии» сонины үнэлэлт дүгнэлт Хятадын бодлогын агуулга мөн чанарыг онож тодорхойлжээ.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал цөмийн дайны аюул ихсэх болсон тухай байдалд марксист дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хэвлэлд нийтэлсэн мэдэгдэлдээ «АНУ уг хэлэлцээг (Женевийн хэлэлцээг—Д. М.) халхавч болгон...америкийн дунд тусгалын пуужинг байрлуулж эхлээд байгаа нь бодит хэрэг боллоо. Байдал нэгэнт ийм болсон учир Зөвлөлт засгийн газар Европт цөмийн зэвсэглэлийг хязгаарлах тухай хэлэлцээнд оролцохоо зогсоож, цэрэг стратегийн тэнцвэртэй байдлыг хэвээр байлгах, ЗСБНХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орны аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авахаас өөр аргагүй болсон байна»¹² гэж цохож тэмдэглэсэн юм.

⁸ Мөн тэнд. (Мөн «Жэньминь жибао»), 1983. 5. 7, II. 6, «Шицзе чжи» сэтгүүлийн 1983. № 4-ийг тус тус үзнэ үү)

⁹ «Новости Монголии», 23 декабря 1983 г.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ «Новости Монголии», 23 декабря 1983 г.

¹² «Үнэн» 1983. II. 27

Бидний дээр иш татсан Болгарын «Ново время» сэтгүүл «хятадын удирдагчдын жанжлалын бодлого, зөвлөлтийн эсрэг үзэл өөрчлөлтгүй хэвээр байна» гэсэн өгүүлэлдээ улс орноо улс хоорондын харилцаанд нөлөө эзэмшлийн бүс нутаг бүхий «хэт их гүрэн» болгож хувиргах гадаад бодлогын стратегээ Бээжингийнхэн хэвээр баримталсаар, энэ зорилгоо биелүүлэх арга ажиллагаандаа ч өөрчлөлт оруулсангүй явж ирсэн тухай дурджээ.

Мөн нийгэм-эдийн засгийн хоёр системийн зөрчлийн дунд сольбиж, улс, төр, дипломат алба, суртал нэвтрүүлгийн элдэв кампанийн туслалцаатайгаар ЗХУ, АНУ-ын хоорондын хурцадмал байдлыг тогтмол дээд цэгт байлгах, үүн дундаас ашиг хонжоо хайж олох гэх явдал хятадын удирдагчдын өмнөх жилүүдийн практик байсан, одоогийн тактик ч мөн ийм байгаа талаар социалист Болгар улсын хэвлэл шударгаар тэмдэглэсэн байна.

Энэ дүгнэлтийг бусад олон хэрэг явдлын зэрэгцээгээр Хятадын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Чжао Цзыяны АНУ-д 1984 оны эхээр хийсэн айлчлалт шинэ баримт материалаар давхар нотоллоо гэх бүрэн үндэс бий. Хятад Ард Улсын ерөнхий сайд «даян дэлхийд энх тайвныг сахин хамгаалахад тус дөхөм үзүүлнэ»¹³ гэж Вашингтонд мордохынхоо өмнө айлчлалынхаа зорилтыг тодорхойлсон боловч АНУ-д очоод Европт зөөж эхэлсэн дунд тусгалын пуужинг татан буулгаж, Женевийн хэлэлцээг үргэлжлүүлэх санал дэвшүүлсэнгүй, харин тухайлан цэрэг зэвсэг, бүр цөмийн зэвсгийн салбарт Америктай хамтран ажиллах хэтийн төлөвлөгөөг авч хэлэлцээнийг юугаар тайлбарлах вэ гэдэг асуудал аяндаа гарч ирж байна.

Одоогийн байдлаар Хятад АНУ-тай хамтран шинжлэх ухаан-техникийн 150 орчим төслийг өөрийн газар нутаг дээр барилга байгууламж болгон хэрэгжүүлж байгаа бөгөөд АНУ-ын ерөнхийлөгчийн мэдэгдсэнээс үзэхэд Хятадад оруулж байгаа америкийн хөрөнгө оруулалт бусад аль ч орныхоос давж байгаа ажээ. Гэтэл дээрхи тоо бол Чжао Цзыян, Рейган нарын хэлэлцээний өмнөх үеийн байдлыг тодорхойлсон албан ёсны мэдээ билээ.

Шинэ хэлэлцээний гол нь Хятадад «эдийн засгийн шинэтгэл» хийхэд америкийн үйлдвэр-худалдааны бүлгийнхний оролцоог идэвхжүүлэх, хятадын эдийн засагт оруулах америкийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгджээ.¹⁴ Чжао Цзыян Вашингтонд хэлсэн үгэндээ энэ удаагийн айлчлалт «**Зохих төвшинд ?!**—Бид онцлов, Д. М.) хүртэл өргөжиж чадахгүй байгаа хятад-америкийн харилцааг тогтвортой хөгжүүлэх» бололцоог олгоно гэж найдаж байгаагаа илэрхийлсэн байна.¹⁵ Рейганы засаг захиргааны төлөөлөгч хятадын засгийн газрын тэргүүний энэ удаагийн айлчлалын өмнө тавигдсан зорилго «АНУ-ын хувьд бүрэн биелэгдсэн»¹⁶ тухай мэдэгджээ. Гэвч Хятадын ерөнхий сайдын үгэнд гарсан хоёр орны харилцааг «зохих төвшинд» хүргэж хөгжүүлэх гэсэн томъёолол, АНУ-ын зорилго энэ удаад бүрэн биелэгдсэн» гэсэн тодорхойлолтын цаана чухам юу нуугдаж байгааг одоогоор тодорхой хэлэх боломжгүй юм. Харин Чжао Цзыян «Хятад-америкийн харилцаа хоёр талын ердийн харилцаагаар хязгаарлагдахгүй, энэ харилцаа дэлхий данхины байдалд нөлөөлөгч хүчин зүйл болох ёс-

¹³ «Новости Монголии», 6 января 1984 г.

¹⁴ «Үнэн» 1984. I. 13.

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ «Правда», 14 января 1984 г.

той»¹⁷ гэж мэдэгдсэн явдал бол зүйлд түлхүүр бол байна. Мөн АНУ «Зөвлөлт, америкийн харилцааг улам ээдрээтэй болгоход «хятадын хүчин зүйлийг» ашиглахыг оролдож, «энэ хэрэгт АНУ-ын бодлогод бага түншийн ёсоор хамсан оролцогчийн үүргийг Хятад улсад ноогдуулж»¹⁸ байгаа нь нотлогдлоо.

Урьд өмнө гарсан хамтарсан албан мэдээнд тусгагдсан зарчмуудыг хоёр тал гуйвалтгүй баримтлах нь хятад-америкийн харилцааг цаашид хөгжүүлэх нөхцөл мөн»¹⁹ гэж хятадын ерөнхий сайд хэлсэн байна. Үүнийг хятадын удирдагчид америкийн империализмтэй холбоотон болтлоо ойртсоноо нэхэн сануулж, тэр байр-сууринаасаа ухраагүй гэдгээ нотолсон үг гэж ойлгохоос өөр аргагүй юм. Мөн «олон улсын нэлээд асуудлаар юм»²⁰ гэж Чжао Цзыяны хэлсэн үг анхаарал татаж байна.

Тайваний асуудал дээр Хятадын удирдагчид Вашингтонд очоод «цаасан бар» мэт зөөлөрчээ. Ийнхүү хятадын зочин Вашингтонд очоод Тайваньд зэвсэг нийлүүлэх явдлаа «даруй түргэн, бүрмөсөн» зогсоохыг шаардаж, Рейганд дарамт шахалт үзүүлэхгүй байх гэж урьд нь тоймчдын бичиж байсан таавар нотлогдов.

«Индонезия таймс» 1983 онд хятадын далай цэргийн хүч нэлээд хүчтэй болсныг дурдаад, АНУ-аас Хятадад нийлүүлэх цэргийн ба иргэний зориулалттай үйлдвэрийн технологи, барааны экспорт үлэмж ихсэх болсон хийгээд онгоц тээгч 5 хөлөг онгоц, баллестик пуужин тээвэрлэгч усан доогуур явах хэд хэдэн атомын завийг АНУ төхөөрөмжлөх юм гэдгийг зааж тэмдэглэсэн байна.²¹ «1983—1985 онд АНУ-ын батлан хамгаалах хүчнийг хөгжүүлэх төдөвлөгөө» гэсэн баримт бичигт «хоёр орны холбоо хэлхээг бататгаж Хятадад зэвсэглэлийн талаар тусламж үзүүлэх» удаан хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай заагаад, дайны нөхцөл байдалд материал-техникийн хувьд хятадын зэвсэгт хүчний ажиллагааг зохицуулан хангаж, уул бүс нутагт ЗХУ-ын цэрэг зэвсгийн хүчийг хятадын армиар «тогтоон бариулах» тактик явуулах тухай илэн далангүй өгүүлжээ. Гэтэл Бээжин энэ тухай болон бусад олон асуудлаар төдийлөн үг дуугарахгүй байгаа нь ТАСС-ын тайлбар өгүүлэлд тэмдэглэсэнчилэн «АНУ-ын бодлогоос тодорхой хэмжээнд зай барьж» ийм замаар дэлхий нийтийн өмнө нэр хүндээ гутаахаас зайлсхийсэн явдлаар тайлбарлагдаж байна.²² Америкийн империализмын тухайд гэвэл «өөрийн нөлөөний хүрээнд Хятад улсыг улам татан оруулах, зөвлөлтийг илт эсэргүүцэх зорилгоор америк-хятадын харилцааг илүү тогтвортой үндэс суурьтай болгоход»²³ хятадын удирдагчдыг, тухайлан хятадын засгийн газрын тэргүүний 1984 оны эхээр АНУ-д хийсэн айлчлалтыг ашиглах бодолтой байсан нь²⁴ тодорхой.

Энэ нь 4-р сарын сүүл үеэр америкийн засаг захиргааны тэргүүн Рейганы Бээжинд зочилсон зочилолтын үеэр давхар нотлогдлоо. АНУ-ын ерөнхийлөгч Хятадад очоод «Азид байрлаж байгаа зөвлөлтийн пуужингууд оромноосоо хөдлөөгүй цагт АНУ ЗХУ-тай Европод цө-

¹⁷ «Үнэн» 1984. 1. 13

¹⁸ «Үнэн» 1984. 1. 17

¹⁹ «Үнэн» 1984. 1. 13

²⁰ «Новости Монголии» 10 января 1984 г.

²¹ «Новости Монголии» 10 января 1984 г.

²² «Үнэн», 1984. 1. 17

²³ Мөн тэнд. 2

²⁴ Мөн тэнд.

мийн зэвсэгийг хорогдуулах ба устгах асуудлаар хэзээ ч хэлэлцээр байгуулж гарын үсэг зурахгүй» гэж яаран мэдэгдсэн нь дэлхийн улс түмний анхаарлыг нэн түрүүнд татсан юм. Энд өгүүлэгдэн бүхий пуужингууд бол ЗХУ-ын нутгийн Азийн хэсгийг Ази-Номхон далайн бүс нутгаас онилсон америкийн зэвсгээс хамгаалах зорилготой нь тодорхой байсаар атал энэ асуудлаар америкийн засаг захиргаа хятадын удирдагчдын санал бодол «тохирч таарч» байгаа явдал ноцтой байна.

АНУ-ын хэвлэл «Ерөнхийлөгч улаан Хятадыг харааж дайрахаа болилоо. БНХАУ ч шинэчлэлийн программынхаа хувьсгалч ёсны «цэвэр тунгалаг» зарчмаас ухарсан байна. Өнөөдөр Бээжингийн гудамжаар хувьсгалч уриа лоозон бус, харин барууныхны эд таваарыг гоёчлон магтсан зурагт хуудас үзэгдэх нь олонтой—гэж Америк, Хятадын түншлэлийн нүүр царайг дүрслэн бичжээ.

«Вашингтонынхон худалдаа, эдийн засгийн асуудлыг аман дээрээ тэргүүн зэрэгт дэвшүүлэн тавьж байгаа нь Вашингтоны жинхэнэ төлөвлөгөөнөөс анхаарал холдуулж, «стратегийн хамтын ажиллагаанд Хятадыг татан оролцуулах үндэс суурь бэлтгэхэд чиглэсэн АНУ-ын засаг захиргааны заль мэх мөн»²⁵ гэж ЗХУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зөвлөлтийн олон нийт үзсэн нь америк, хятадын түншлэлийн асуудалд хийсэн бодитой, буурьтай дүгнэлт болж байна.

х х х

Хятадын удирдагчдын гадаад бодлогод Японтой харилцах харилцаа урьдын адил тодорхой хүчин зүйл хэвээр байна. ХКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан 1983 оны 11-р сарын сүүлээр Токиод орж Японы ерөнхий сайд Накасонэтэй хийсэн хэлэлцээний үеэр хоёр тал «харилцан ойлголцох, итгэлцэх, НҮБ-ын дүрэмд нийцүүлэн хүч үл хэрэглэх үндсэн дээр бүх асуудлыг шийдэж» байхаар²⁶ тохиролцжээ. «XXI зууны япон-хятадын нөхөрлөлийн хороо» гэгчийг байгуулах японы саналыг ХКН-ын тэргүүн зарчмын хувьд зөвшөөрсөн байна.²⁷ Тухайлбал «XXI зууны нөхөрлөлийн хороо» гэгч чухам ямар зориулалттай, юу хийх байгууллага болох нь одоогоор хараахан бүрхэг байгаа боловч Японтой харилцах харилцаатай уялдан гарч ирж байгаа Алс Дорно дахины асуудлаархи Хятадын байр суурь тун тодорхой байна гэдгийг хэлэх хэрэгтэй. Гэвч Бээжингийн удирдагчдын байр суурь бодитой биш, жанжлалын үзэл бодлын тод амьсгалтай байгаа нь хачирхал зэвүүцэл төрүүлэхэд хүрч байгаа юм. Бидний дээр иш татсан БКН-ын Төв Хорооны хэвлэлд цэргийн салбар дахь АНУ-Японы хамтын ажиллагаа шуудран хэрэгжиж, японы милитаризм сэргэж байгааг Бээжин Алс Дорнодахинд ЗХУ-ын «цэрэг дайны бэлтгэл идэвхжиж байгаа» гэгч шалтгаанаар цагаатгахыг оролдсоор ирлээ²⁸ гэж дурджээ. Өөрөөр хэлбэл АНУ дунд зайны пуужингаа Европт байрлуулж, Женевийн хэлэлцээг таслахаас аргагүй байдалд оруулсан ноцтой хэрэг явдлын тухайд явуулсан өөдгүй бодлоготой нь Алс Дорнод дахь хятадын бодлого явцав нийцэж байна. Цаашилбал цөмийн салбарт хамтран ажиллах япон-хятадын хэлэлцээг тодорхой үр дүнд хүргэн хэрэгжүүлэх үе шатанд ороод байна.²⁹

БНХАУ-ын удирдлага японы зүгээс ЗХУ-д тавьж байгаа нутгийн өнгөлзлөгийг дэвэргэн дэмжиж, японы милитаризм цөмийн зэв-

²⁵ Мөн тэнд.

²⁶ «Правда» 29 ноября 1983 г.

²⁷ Мөн тэнд.

²⁸ «Новости Монголии», 25 ноября 1983 г.

²⁹ «Киодо Цусин» агентлагийн мэдээ («Правда», 17 декабря 1983 г)

сэглэлийн хэлбэрээр дахин өндийж дайны аюулыг ихэсгэж байгаа эгзэгтэй энэ үед, Японы удирдах бүлгийн хамгийн харгис хэсэгтэй дуу хоолойгоо нийлүүлж байгаа баримтыг цохон тэмдэглэлтэй. Өнгөрсөн оны сүүлээр Хятадын ГЯЯ-ны сайд «Хойт талын дөрвөн арлаа буцааж авах Японы шаардлагыг Хятад улс шийдвэртэй дэмжиж байна» гэж хийсэн мэдэгдлийг «Правда» сонин 1983 оны 11-р сарын 30-ны дугаартаа шүүмжлэн няцаасан билээ. Бээжингийнхний энэ мэт байр суурины цаана хятадын удирдагчдын өөрсдийнх нь сэдэж зохиосон «газрын зураг зүйн» түрэмгийлэл, бусдын нутагт өнгөлзөх, түүхийг мушгин завхруулах чиг шугам, арга ажиллагаа нуугдаж байгаа нь бүр ч анхаарал татаж байна.

Р. Рейган, Ж. Шульц нар Алс Дорнодод ЗХУ –ын явуулж байгаа бодлогыг мушгин гуйвуулах гэж чухам Бээжингийн албан хүмүүстэй хийсэн хэлэлцээний үеэр дахин хүчтэй оролдсон хийгээд Японд Ху Яобаны айлчилсны халуун мөрөөр Чжао Цзыян АНУ-д мордсон зэрэг нь санамсаргүй хэрэг биш болохыг эцэст тэмдэглүүштэй.

Хятадын удирдагчдын Энэтхэг-хятадын гурван орны талаар явуулж ирсэн бодлогод ямар нааштай өөрчлөлт орохыг Ази дахины аюулгүй байдлыг эрхэмлэгч улс орон, ард түмэн харж хүлээсээр байлаа. Гэвч Бээжин энэ хүлээлтийг ажин түжин байдлаар хариулсан төдийгүй, ялангуяа улс орныг нь сүйрэл мөхлийн ирмэгт аваачсан харгис хүчнийг бут цохиж үндэсний дахин сэргэлт, шинэ амьдралын бүтээн байгуулалтын замд гарсан Кампучийн ард түмний эсрэг улайрсан тэмцэл явуулсаар байна. Үүний хамгийн сүүлийн үеийн нэн ноцтой баримт бол Бээжин огт байхгүй «Ардчилсан Кампучи улс» гэгчийн төлөөлөгч нэрийн дор Кампучийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнөөр таягдан зайлуулагдсан Сианук нарын гурван хүнийг найр тавин хүлээн авч, «Ардчилсан Кампучийн» «эвслийн засгийн газрын» энэхүү «төлөөлөгчид гэгчтэй хэлэлцээ явуулж, хойшид ч ганзага нийлэн, «туслан дэмжинэ» гэдгээ илэрхийлсэн³⁰ явдал мөн. Энэ бүхэн нь угтаа БНХАУ-ын улс төрийн гадаад бодлогын мөн чанарт Маогаас хойш зарчмын гүнзний өөрчлөлт гараагүйг харуулж буй бөгөөд үүнийг Бээжин өөрөө ч хүлээн зөвшөөрч, тунхаглаж байгаа юм. Мао Зэдуны төрсний 90 жилийн ойд зориулж 1983 оны сүүлээр болсон хэвлэлийн бага хурал дээр Хятадын удирдагчид маоизмд үнэнч гэдгээ давтан нотолж, «МАО Зэдуны үзэл санааг хамгаалан хөгжүүлэх хэрэгт» ХКН-ын Төв Хороо тухайлан Дэн Сяопин «асар их хүчин зүтгэл» гаргаж байгааг³¹ сурвалжлагчдад мэдэгдсэн билээ.

Гэвч империализмтэй цэрэг, улс, төр, эдийн засаг, ялангуяа цөмийн салбар хамтран ажиллах Дэн Сяопин нарын маоизмыг «хамгаалан хөгжүүлэгч» чиг шугамыг бүрэн хуваалцахгүй тийм хүч Бээжингийн удирдлагад байгаа нь тухайлан социалист орнуудын хэвлэлийн мэдээнээс харагдаж байна. Вьетнамын «Куансдой Нян Зан» сонин «...хятадын удирдагчдын доторхи харгис хүч (бид онцлов,--Д. М.) Кампучи, Вьетнам, Лаосын тухайд дайсагнасан бодлого буцалтгүй хэвээр үргэлжлүүлсээр байгаа» тухай бичсэн бол БКН-ын ТХ-ны хэвлэлд Дэнгийн чиг шугамд хятадын нийгмийн олон нийт төдийгүй, намын удирд-

³⁰ «Правда» 12 декабря 1983 г.

³¹ «Правда» 30 декабря 1983 г.

лагын тодорхой хэсэг дургүйцэж байгаа тухай өгүүлснийг бид нэгэнт тэмдэглэсэн билээ.

Хятадын гадаад бодлогод эцсийн эцэст ЗХУ-тай хийж байгаа хэлэлцээ, олон улсын тулгамдсан бусад олон асуудал хүн төрөлхтөний энх амгалан, Азийн аюулгүй байдлын эрх, ашиг, ангийн байр сууринаас бодитой хандах хандлага, Зөвлөлт-хятадын хамтын ажиллагааны зарим салбарт ажиглагдаж буй бага ч болов ашигтай үрийг тордон хөгжүүлэх эрүүл саруул үзэл бодол давамгайлж, хятадын ард түмэн цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулахад тодорхой хувь нэмэр оруулах үүрэг хариуцлага эрх биш байх ёстой билээ.

К НЕКОТОРЫМ ВОПРОСАМ ВНЕШНЕЙ ПОЛИТИКИ КИТАЯ (Резюме)

Д. Маам к.и.н.

На февральском пленуме ЦК КПСС товарищ К. У. Черненко сказал, что «успех дела сохранения и укрепления мира в значительной мере зависит от того, насколько велико будет влияние на мировой арене социалистических стран, насколько согласованы будут их действия»¹. Это в полной мере относится к «великому соседу» Советского Союза—КНР². Автор в статье показывает, как реагирует китайское руководство на принципиальные призывы и добрые намерения ленинской партии, исходящие из традиционно миролюбивой политики СССР, а также рассматривает позиции китайского руководства по другим актуальным международным проблемам на этом ответственном этапе развития международной жизни.

Тогда как Советский Союз принимает последовательные меры для того чтобы нормализовать и улучшить отношения с КНР, рассматривая это как важную составную часть борьбы за мир, социализм, за предотвращение войны, заявления китайских руководителей о желании нормализовать отношения сопровождаются выдвижением заведомо неприемлемых условий, направленных на то, чтобы устроить завалы на пути такой нормализации.

Что вызвало коррективы или так называемые новые нюансы, которые вносит китайское руководство в некоторых своих внешне-политических акциях? Этому послужило, во-первых, то, что провалились попытки руководителей Китая создать задуманный им «Широкий международный фронт» против СССР и социалистического содружества; во-вторых, откровенная проимпериалистическая политика Дэн Сяопина и его приверженцев, которая нанесла серьезный вред престижу КНР среди развивающихся стран.

Что касается китайско-американских отношений, то взаимные визиты китайских и американских руководителей показали, что по наи-

¹ «Правда» 14 февраля 1984 г.

² «Правда» 23 февраля 1982 г.

более важным проблемам современности позиции США и КНР весьма близки. Идет ли речь об американских ракетах в Европе, об Афганистане, базах США на Дальнем Востоке, о Кампучии или Японском милитаризме — всюду можно найти, что взгляды Пекина и Вашингтона на эти проблемы в той или иной степени совпадают. Например, на Дальнем Востоке вблизи границ Советского Союза находится вторая по мощи заморская группировка американских сил. А Китай постоянно углубляет сотрудничество с этой военной машиной империалистов. Более того, отказываясь от советских предложений в выработке мер доверия, китайское руководство продолжает держать более половины вооруженных сил КНР на границах с Советским Союзом и МНР.

Из сказанного в статье видно, что китайское руководство продолжает смотреть на современный мир сквозь призму гегемонизма и антисоветизма, игнорируя подлинные источники растущей военной опасности, суть которых в резком усилении авантюризма империалистических держав, прежде всего США.